



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 2/366

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2007 оны 187 дугаартай тогтоол, отрын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай тогтоолын хавсралт-5, хавсралт-13 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн Баян-Улаан тосгоны отрын бүс нутгийг чөлөөлөх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Дарханбаатар

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
дарга

Гишүүдэд:

Л.Цэнгэл

Жаргалтхаан сумын Засаг  
дарга

Э.Төгөлдөр

Дэлгэрхаан сумын Засаг дарга

С.Золжаргал

Цэнхэрмандал сумын Засаг  
дарга

Д.Батсүрэн

Жаргалтхаан сумын сум  
дундын  
цагдаагийн тасгийн дарга,  
Хошууч

Ж.Тайванжаргал

Дэлгэрхаан сумын отрын бүс  
нутгын төлөөлөгч

2.Хэрлэн Баян-Улаан тосгоны отрын бүс нутгийг чөлөөлөх мэдэгдэл хүргүүлж 2023 оны 7 дугаар сарын 01-ний дотор нүүлгэж отрын бүс нутгийг чөлөөлүүлсэн байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ